

БНХАУ-ЫН БАРУУН БҮС НУТГИЙН ЗАМ ХАРИЛЦААНЫ ХӨГЖЛИЙН ТАЛААР ТОВЧ ӨГҮҮЛЭХ НЬ

*Н.Төмөр**

Аливаа улс орны эдийн засгийн хөгжил тухайн орны зам харилцааны хөгжилтэй шууд холбоотой байдаг. БНХАУ-ын Засгийн газар тус улсын зам харилцааг хөгжүүлэх талаар тууштай бодлого баримтлан Баруун бүс нутгийн зам харилцааг хөгжүүлэх асуудалд мөн нэгэн адил анхаарал тавьсаар ирсэн. Тухайлбал, 2002 оны 3-р сард хуралдсан БХАТИХ-ын 9 дэх удаагийн сонгуулийн 5-р чуулган дээр Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Засгийн газрын ажлын тухай илтгэлдээ, Хөх нуур-Төвд чиглэлийн төмөр зам барьж байгуулах ажлыг хүч чармайлт гарган сайн хийх хэрэгтэй гэж онцлон заажээ¹. БНХАУ-ын Тээвэр холбооны Яамны сайд Хуан Чжэндун тус улсын зам харилцааны хөгжлийн талаар ярихдаа, 2001 оны 1-р сараас 11-р сар хүртэл Баруун бүс нутгийн авто зам барьж байгуулахад оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ өнгөрсөн оны мөн үеийнхээс 23 хувиар өссөн ба 2002 онд 40 мян. км авто зам шинээр тавих бөгөөд 2500 км нь өндөр хурдны зам байх юм гэжээ².

БНХАУ-ын Засгийн газар 2001 онд авто зам барьж байгуулахад нийт 260 гаруй тэрбум юаний хөрөнгө зарцуулж, 320 мян. км авто зам шинээр тавьж, үүнээс 3017 км нь өндөр хурдны зам бөгөөд 2001 оны эцсийн байдлаар Хятад улсын авто замын нийт урт 1698 мян. км болж, үүнээс 19 мян. км нь өндөр хурдны зам байв³.

Хятад улсын Баруун бүс нутгийн авто замын харилцаа тус бүс нутгийн зам харилцаанд чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ бүс нутгийн эдийн засгийн хөгжил бусад эдийн засгийн бүсүүдтэй харьцуулахад нэлээд хоцрогдонгуй, ихэнх нутаг нь өндөр уул, говь бүсэд хамарах ба энэ нь зам харилцааг хөгжүүлэхэд нэлээд бэрхшээл учруулдаг. Баруун бүс нутаг Хятад улсын бүх газар нутгийн 56 хувийг эзэлдэг боловч авто замын хэмжээгээр бүх Хятадын авто замын нийт хэмжээний ердөө л 30 хувийг эзэлж, үүнд дийлэнх хэсэг нь буюу 93 хувь нь 2-р зэрэглэлийн зам юм. 1999 оны байдлаар тус бүс нутгийн авто зам барьж байгуулахад оруулсан хөрөнгийн хэмжээ нь 40,07 тэрбум юань байсан

*Н.Төмөр - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

нь бүх Хятадын энэ чиглэлд оруулсан хөрөнгийн хэмжээний 2,35 хувийг эзэлжээ⁴.

2001 оны байдлаар Хятад улсын төмөр замын нийт урт нь 70,1 мян. км болж, үүнээс 17 мян. км замыг цахилгаанжуулжээ. Тус улсын улс ардын аж ахуйн хөгжилд нэлээд ач холбогдол бүхий Бээжин-Цзюлун, Наньнин-Куньмин, Турфан-Кашгар, Ханьданы-Цзинань, Баоцзи-Чэнду чиглэлийн төмөр замыг барьж дуусган ашиглалтанд оруулжээ. 2002 онд төмөр зам барьж байгуулахад нийт 56,0 тэрбум юаний хөрөнгө оруулах ба шинээр 1250 км зам тавихаар төлөвлөжээ⁵.

Хөх нуур-Төвд чиглэлийн Голмуд хотоос Лхаса хот хүртлэх 1118 км урт бүхий төмөр замыг барьж байгуулах ажлыг Хятад улсын Засгийн газар 2001 оны 6-р сард эхлүүлж 6 жилийн дараа буюу 2007 онд ашиглалтанд оруулах зорилт тавьжээ. Хөх нуур-Төвд чиглэлийн төмөр зам нь БНХАУ-ын Баруун бүс нутагт орших Хөх нуур мужийн төв Синин, ТӨЗО-ы төв Лхаса хоёр хотыг холбосон төмөр замыг хэлнэ. Энэ чиглэлийн төмөр замыг ашиглалтанд оруулснаар Ганьсу мужийн төв Ланьжоу, Хөх нуур мужийн төв Синин, ТӨЗО-ы төв Лхаса зэрэг хотуудыг төмөр замаар холбож Баруун бүс нутгийг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Дээр дурдсан төмөр замын 1-р ээлжийн барилга байгууламж болох Хөх нуур мужийн Синин-Голмуд чиглэлийн төмөр замыг /846 км/ 1984 онд ашиглалтанд оруулсан ба Голмудоос Лхаса хүртлэх замыг /1118 км/ барьж байгуулах ажил 2001 оны 6-р сард эхэлжээ⁶.

БНХАУ-ын Баруун хойд бүс нутагт орших ӨМӨЗО-ы зам харилцааны хөгжлийн талаар товч өгүүлье. ӨМӨЗО-ы зам харилцаа ерөнхийдөө сайн хөгжсөн. Өнөөгийн байдлаар ӨМӨЗО-ы авто замын нийт хэмжээ нь 63800 гаруй км бөгөөд энэ нь тус ӨЗО-ы хөдөө тосгоны 95,5 хувийг авто замаар холбосон гэсэн үг юм. Сүүлийн 20 жилд Шилийн хот-Баочан-Жанжякоу /Чуулалт хаалга/, Якши-Манжуур, Хөх хот-Вангийн сүм, Тунляо-Улаан хот зэрэг хот хоорондын авто замыг шинээр барьж ашиглалтанд оруулснаас гадна Бугат, Линхэ /Баян нуур аймгийн төв/ зэрэг томоохон хотуудын хот орчмын авто замыг барьж байгуулан, ялангуяа 1997 онд ӨМӨЗО-ы төв Хөх хотыг тус ӨЗО-ы хоёрдугаар том хот болох Бугаттай холбосон өндөр хурдны замыг ашиглалтанд оруулснаар ӨМӨЗО-д өндөр хурдны замгүй байсан түүхийг төгсгөл болгож ӨМӨЗО-ы “Алтан гурвалжин” болох Хөх хот, Бугат, Их зуу аймгийн ачаа тээврийн асуудлыг бүрэн шийдвэрлэжээ. Үүний зэрэгцээ Хөх хот-Бугатын өндөр хурдны замыг барьж байгуулах

2-р ээлжийн ажил болох 151 км урт бүхий замыг 2000 оны 7-р сараас барьж эхэлжээ. Энэ замыг барьж байгуулахад 1,5 тэрбум юаний хөрөнгө шаардлагатай гэж мэргэжилтэнгүүд тооцоолжээ. Хөх хот-Бугатын өндөр хурдны замын 2-р ээлжийн барилга байгууламж нь ӨМӨЗО-д хэрэгжүүлж буй Баруун бүс нутгийг хөгжүүлэх дэд бүтцийн анхны байгууламж бөгөөд энэ зам нь Баруун бүс нутгийг Бээжин болон тэнгисийн гарцтай хотуудтай авто замаар холбоход чухал ач холбогдолтой.

21-р зууны эхний арван жилд ӨМӨЗО-ы авто замын харилцааг хөгжүүлэхэд дор дурдсан 5 зүйл бүхий зорилт тавив. Үүнд: Нэгдүгээрт, Вангийн сүм-Хөх хот -Бугат-Линьхэ-Ухай зэрэг хотуудыг холбосон өндөр хурдны зам /Вангийн сүмээс Бугат хүртлэх замыг 2005 оны өмнө ашиглалтанд оруулахаар төлөвлөв/ барьж байгуулах ба энэ авто замыг ашиглалтанд оруулснаар Баруун бүс нутгийг Бээжин, Тяньжин зэрэг томоохон хотуудтай өндөр хурдны замаар холбож, Хөх хотоос Бээжин орох хугацааг 2 цагаар богиносгох боломж нөхцлийг бүрдүүлэх / Хөх хотоос Бээжин ороход 6-7 цаг зарцуулж байсан бол өндөр хурдны авто замыг ашиглалтанд оруулснаар 4-5 цаг зарцуулах болно/ ; Хоёрдугаарт, ӨМӨЗО-ы Манжуур-Хайлар-Улаан хот-Тунляо-Улаанхад-Жинин-Хөх хот-Дуншэн-НХӨЗО-ы /Нинся Хотонгийн Өөртөө Засах Орон/ төв Иньчуан зэрэг хотуудыг холбосон дардан зам барьж байгуулах; Гуравдугаарт, Аршааны баруун хошууг Эзний хошуу зэрэг газар нутагтай холбосон 11 авто зам барьж байгуулах; Дөрөвдүгээрт, Түмт баруун хошууг Лянчэнь зэрэг хот сууринг холбосон 12 авто зам барьж байгуулан, улмаар энэ газар нутагт авто замын сүлжээг бий болгох; Тавдугаарт, ядуурлыг бууруулах бодлоготой уялдуулан ӨМӨЗО-ы бүх гашаа, тосгоныг ямар нэгэн хэмжээгээр авто замаар холбосон байх гэсэн 5 зүйлт зорилт тавьж, 2005 он гэхэд авто замын нийт хэмжээг 76000 км-т, өндөр хурдны замын хэмжээг 500 км-т тус тус хүргэнэ гэжээ⁷.

Өнөөгийн байдлаар ӨМӨЗО-д улсын төмөр замын 14 гол шугам, 12 салаа шугам, орон нутгийн 5 шугам нийт 125 мян. гаруй км урт бүхий төмөр зам ажиллаж байгаагаас гадна Эрээн өртөөг Монгол улсын Замын Үүд өртөөтэй, Манжуур өртөөг ОХУ-ын Сибирийн төмөр замтай тус тус холбосон олон улсын 2 төмөр зам нь хөрш орнуудын эдийн засаг, худалдааны харилцааг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой.

БНХАУ-ын нийслэл Бээжинтэй холбосон Бугат-Бээжингийн төмөр зам нь зөвхөн Бээжин, Бугат хоёр хотыг холбоод зогсохгүй, ӨМӨЗО-ны төв болох Хөх хотыг Бээжинтэй мөн холбожээ. Бугат-Ланьжоугийн төмөр зам нь ӨМӨЗО-ы хоёрдугаар том хот болох Бугатыг Ганьсу мужийн төв Ланьжоутай холбосноор ШУӨЗО-ы /Шинжаан Уйгурын Өөртөө Засах Орон/ төмөр замтай холбож, улмаар ӨМӨЗО-ыг Европын орнуудын төмөр замтай холбох боломжтой болгов. Бугат-Бээжингийн төмөр зам нь замдаа Шаньси мужийн Датун хотыг дайран өнгөрдөг учраас Бугатыг-Датун-Цинхуандао /Цинхуандао-Хэбэй мужийн тэнгисийн гарцтай усан боомт хот / чиглэлийн төмөр замаар Цинхуандао хоттой холбож, улмаар тэнгисийн гарцгүй ӨМӨЗО-ыг тэнгисийн гарцтай болгов. ӨМӨЗО-ы орон нутгийн төмөр замаас Жинин -Тунляогийн төмөр замыг дурдаж болох бөгөөд 1995 онд ашиглалтанд орсон нийт 943 км урт бүхий энэ төмөр зам нь ӨМӨЗО-ы 4 аймаг, 13 хошуу саяний төвүүдийг холбож, тус ӨЗО-ы эдийн засаг, худалдааг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг билээ.

21-р зууны эхний арван жилд ӨМӨЗО-ы төмөр замын харилцааг хөгжүүлэхэд дор дурдсан 4 гол зорилт тавьжээ. Үүнд : Нэгдүгээрт, Сангийн далай-Чуулалт хаалга, Улаанхад-Дабан, Имин-Ирс, Ухай-Дүншэн зэрэг чиглэлийн төмөр замыг баьж байгуулснаар Тяньжингийн боомт, Жинжоугийн боомт, Түмэн голын /Хуньчунгийн/ боомт болон Хуанхуагийн боомт зэрэг тэнгисийн боомт хотуудтай холбох боломж нөхцлийг бүрдүүлэх; Хоёрдугаарт, Жинин -Тунляо чиглэлийн төмөр замын тээвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх; Гуравдугаарт, Жинин-Бугат чиглэлийн төмөр замын техникийн түвшинг дээшлүүлэн, Бээжингээс Бугат хүртэл төмөр замаар явах хугацааг багасгах; Дөрөвдүгээрт, Харбин-Манжуур, Жинин-Эрээн чиглэлийн төмөр замыг техникийн сааталгүй ажиллуулан улмаар ОХУ, Монгол улсын төмөр замтай холбосон олон улсын төмөр замын ачаа тээврийн хэмжээг нэмэгдүүлэх зэрэг зорилтууд тавьжээ⁸.

ИШЛЭЛ ЗҮҮЛТ

1. Бээжин ревью, сэтгүүл, 2002, №14
2. Солонго, сэтгүүл, 2002, №6
3. Китай 2002, Издательство “Синьсин”, Пекин, 2002, 104 дэх тал.
4. Тан Рун-ан, Ли Юньтай, Баруун бүс нутгийг ихээхэн хөгжүүлэх, Хайку, 2000, 232 дахь тал.
5. Китай 2002, Издательство “Синьсин”, Пекин, 2002, 105 дахь тал. Солонго, сэтгүүл, 2002, №6
6. Солонго, сэтгүүл, 2001, №6
7. Хятад улсын Баруун бүс нутаг-Өвөр Монгол, Бээжин, 2001, 40-42 дахь тал., Монгол улс, БНХАУ-ын ӨМӨЗО-ы найрсаг харилцаа, хамтын ажиллагаа, Хөх хот, 2001, 30 дахь тал.
8. Хятад улсын Баруун бүс нутаг-Өвөр Монгол- Бээжин, 2001, 38-40 дэх тал.,